

Манмин Мэдээ

№ 40 2013 оны 11 сарын 3

Дэлхийн хязгаарт орших Израйльд цэцэглэсэн үзэсгэлэнт үр жимс

“Доктор И Жей руг пасторын Израйльд хийсэн ариун үйлсийг бид хэзээ ч мартаггүй”



И Жей руг пасторын 2009 онд Иерусалимд олон улсын соёлын төвд “Бурхан бол Бүтээгч” сэдвээр хийсэн Израйлийн нэгдсэн их цуглаан. И Жей руг пасторын өвчин эдгээх залбирлын дараа маш олон хүн эдгэрсэнээ гэрчлэхээр тайзан дээр гарч ирж байгаа нь. Түүнээс хойш олон цуглаан, хөгжмийн их наадам, залуучуудын кэмпиог Кристал Форум Израйльд зохион явуулсан. Мөн түүнчлэн ном, сонин, хэвлэл мэдээлэлийн хэрэгсэлээр пасторууд болон итгэгчид Ариун Сүнсний хийсэн гайхамшигуудыг харж, итгэлээр өсөж байгаа билээ.

2013 оны 9-р сарын 5нд Израйлийн Тел Авив дахь Ливинг Стөүн сүмийн итгэгч нар манай сүмийн тэргүүн пастор И Жей руг пасторын “Итгэлийн хэмжээ” номыг хамтдаа уншиж шинэ оноо халуун дотноор угтсан ивээлтэй цаг болж өнгөрсөн билээ. Библид дээгүүр өнгөрөх баярыг тэмдэглэх болсон үеэс эхлэн хүмүүс Нисан сар (3-р сард эхэлдэг шинэ он тооллын нэр) гэдэг шинэ он тоололыг дагадаг болсон боловч еврейчүүд л өнөөдрийг хүртэл Тишри сар (хуучин он тоолол 9-р сараас эхлэдэг) гэдэг хуучин тоололоо хөтөлж, одоог хүртэл ашигласаар байгаа юм.

Энэ өдөр Еврей хүмүүс “сайн, сайхан жил” болохыг бэлэгдэж гэр бүлээрээ алимыг зөгийн балтай хольж иддэг бол Израйлийн Манмин сүмийн итгэгчид Израйльд үзэсгэлэнтэй үр жимс таригдсаныг харуулж сүнсээр өсөхийн тулд И Жей руг тэргүүн пасторын номыг шинэ оны эхний өдөр уншихаар эхэлсэн нь Израйльд сайн мэдээ тараагдсаны үзэсгэлэнтэй үр жимсийн нэг гэлтэй.

Израйлийн Кристал Форумын ерөнхийлөгч Даниел Розен пастор итгэгчдэд хандан “Энэ номоор дамжуулан бид итгэлээр сүнсээр өсөж, Бурханд тааламжтай, Түүнийг баярлуулсан итгэлтэй болцгооё” гэж түүнд төрсөн санаагаа хэлж, уриалжээ.

Манай Манмин төв сүм нь Израйль руу хандсан Бурханы авралын зорилгыг мэдсэн учраас сүмийн итгэгчид нь Израйлийн үйлчлэлийн төлөө сүм нээгдсэнээс хойш үндэсний хэмжээнд болон дэлхийд сайн мэдээ тараахын төлөө залбирлаар болон бүх талаар бэлдэж байсан юм. Эцэст нь И Жей руг пастор болон сүмийн үйлчлэлийн баг нь сүм анх байгуулагдсаны 25 жилийн ойн баярын өдөр буюу 2007 оны 7-р сарын 25 нд Израйль дахь үйлчлэлийг эхлүүлсэн юм. Тэр үеэс хойш 777 өдөр үйлчлэл хийсэн байна. Тэд Есүсийн өссөн газар болох Назараас эхлээд Израйлийн маш олон газраар явж Бурханы хүч чадал болон Есүс Христийн сайн мэдээг болон Бурханы эрх мэдэлт хүчийг сургаал номлосон.

Израйльд нийт 12 удаа айлчилж, Хайфа, Хадера, Ашдод, Бетлэхэм, Ашкэлон, Беершеба, Ейлот, Тел Авив, Нахария, Иерусалим зэрэг олон газар уулзалт цуглаан хийсэн юм. Израйлийн ард түмэн И Жей руг пасторын номлосон амийн үгийг сонсож, түүний залбирлаар илрэн гарах Бурханыг агуу хүч нөлөөг илчлэн харуулсанаар Израйлийн номлогч нар өөрсөд рүү нь болон Израйлийн ард түмэн рүү хандсан Бурханы хайрыг тэд ойлгож ухаарч эхэлсэн юм.

Эцэст нь Израйлийн Пасторуудын

Холбоо болох Кристал Форум (www.acf.org.il) ыг байгуулан И Жей руг пасторыг Израйлийн төв зүрх нь болсон Иерусалимд урьж, Израйлийн Нэгдсэн их цуглааныг 2009 оны 9-р сарын 6, 7 нд зохион байгуулсан билээ. И Жей руг пастор нь цор ганц бүтээгч болох Бурхан, Есүс Христийн тухай эр зонгтойгоор тунхаглаж байгааг дэлхийн 220 гаруй оронд шууд цацаж, Оросын ТВН, Инлейс, CNL, Дижитал Конго гэх мэт 33 нэвтрүүлгийн төвүүдээр шууд нэвтрүүлсэн юм.

Израйльд хамгийн анх сайн мэдээ тунхаглагдсан боловч харин одоо Есүс Христийг аврагч Эзэнээр хүлээн зөвшөөрдөггүй улс юм. Ихэнх хүмүүс нь ганц бурханд үйлчилдэг иудейн шашинтай. Христэд итгэгч цөөхөн хүмүүс нь нийгмээсээ гадуурхагдан доромжлогддог байсан бол Израйльд хийсэн Нэгдсэн их цуглааны дараа тэд маш их эрч хүчтэй болж, хосуудын семинар, Залуучуудын семинар гэх мэт олон үйлчлэлүүдийг Кристал Форум байгуулагдсан цагаасаа хойш зохион явуулдаг болсон билээ. Мөн тэд эр зоригтойгоор задгай талбайд ард түмний дунд Бурханы нэрийг алдаршуулахаар хөгжмийн наадмыг жил бүр уламжлал болгон зохион явуулдаг болсон.

Израйлийн пасторууд сүмийн итгэгчдийнхээ төлөө И Жей руг пасторын залбирсан гар алчуураар (Үйлс 19:11-12) дамжуулан залбирал хийхэд олон хүмүүс эдгэрч, гэм нүглээ гэмшин хаях гэх мэт маш олон тэмдэгт гайхамшигуудыг харсаар байгаа билээ. Мөн тэд АНУ, Орос, Украин, Болгар, Эстон, Финланд гэх мэт гадаад улс оронд Нэгдсэн их цуглаан хийж Ариун Сүнсний гайхамшигт үйлсийг бодитоор харуулж байна. Христэд итгэгчид GCN TV (Жи Си Эн) (www.gcnetv.org), Оросын ТВН, CNL, Ариун Бурхан TV, Родной TV, интернетээр амийн үг сургаалыг хүлээн авч мөн И Жей руг пасторын номнууд, Манмин мэдээ сонинг уншиж итгэлээр өсөж байгаа билээ.

Даниел Розен пастор “Бид И Жей руг пасторын Израйльд хийсэн үйлсийг хэзээ ч мартаггүй. Ялангуяа, Есүс Христ бол жинхэнэ амьд оршигч Бурханы Хүү гэж 2009 оны Нэгдсэн Их Цуглаанаар тунхаглаж байсан тэр агшиныг хэзээ ч мартаж чадахгүй. Тэр Израйлийн пасторуудыг нэг хүн шиг нэгтгэж, биднийг зоригжуулж чадсан. Израйлийн хүн нэг бүрийн төлөө нулимсаа дуслуулан байж залбирч өгсөнд үнэхээр их талархаж байна. Кристал Форум дахин сэргэж, гайхалтай сайхан ирээдүйгээ харж байгаа” гэж хэллээ.

Хайр муутай тооцоо хийдэггүй

“[Хайр] зохисгүй авирладаггүй, өөрийнхийг эрдэггүй, уурладаггүй, муутай тооцоо хийдэггүй.” (1 Коринт 13:5)



Доктор И Жей руг Тэргүүн Пастор

Хоёр хүн яг адилхан нөхцөл байдлыг харж байна гэж бодъё. Нэг нь их өөдрөг сэтгэлээр хандан эерэг бодолтой байхад нөгөө нь сөрөг зүйл бодон шүүн дүгнэдэг хүн бас байдаг. Мөн өөрт хандан хэлсэн үг биш ч гэсэн үүнийг буруугаар ойлгон эргэн тойрны уур амьсгалыг эвдэх тохиолдол ч байдаг. Сайн санаа эерэг бодол нь амар тайван ба амийг өгдөг бол атгаг бодол санаа нь огтхон ч ашиг тусгүй бөгөөд өөрийн амьдралыг бэрхшээлтэй болгодог. Цаашлаад иймэрхүү сөрөг муу бодлууд бусдад ч бас нөлөөлдөг байна.

Энд гарч байгаа “муу бодлууд” гэдэг нь Бурханы хүсэлтэй нийцэхгүй байгаа зүйлийг хэлж байгаа юм. Тэгвэл бид муутай тооцоо хийдэггүй сүнслэг хайрыг олж авахын тулд яах ёстой вэ?

1. Муутай тооцоо хийхгүй байхын тулд

1) Бусдыг алдаа гаргахыг хүсдэг муу бодлоо хаях ёстой.

Чинээлэг амьдардаг найздаа атаархах сэтгэл танд төрөөд байа гэж бодъё. Тэгвэл хэрэв та “Тэр сайхан амьдарч байхад харин би ямар байна? Түүнд нэг муу юм тохиолдоосой” гэж бодох юм бол энэ нь хорон муу бодол санаа байна. Хэрвээ таны зүрх сэтгэлд сүнслэг хайр байвал танд хэзээ ч ийм муухай бодол орж ирэхгүй.

Хэн ч хэзээ ч хайртай хүнээ өвдөх юм уу, осол аваарт ороосой гэж хүсэхгүй билээ. Та өөрийн хайртай эхнэр, нөхөр, мөн үр хүүхдээ үргэлж эрүүл саруул, өвчин зовлонгүй, гэнэтийн осол, аюулаас хол байгаасай гэж хүсдэг. Гэвч бусдад ямар нэгэн муу юм тохиолдохыг хүсч, бусдын зовлонтой байдлыг хараад баярлаж байвал тэр хэмжээгээр миний сэтгэлд хайр байхгүй байна гэдгийг л илтгэн харуулж байгаа юм. Мөн бусдын алдаа дутагдал болон сул талыг илчлэх, дамжуулах гэдэг хүн ч бас байдаг.

Мэдээж буруу замаас нь засан залруулж зөв зам руу удирдан чиглүүлэхийн тулд тэр

хүний нөхцөл байдлыг үнэн зөвөөр нь мэдэх хэрэгтэй биш л бол бусдын үгэнд анхаарал хандуулах, мэдэх гэж хичээх нь миний сэтгэлд хов жив хөөцөлдөх, хүний мууд дурлах хорон муу сэтгэл байгаа болохыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй билээ.

Сургаалт үгс 17:9д “Нүгэл хилэнцийг далдлагч хайрыг эрдэг. Харин хэргийг дахин дахин ярьдаг хүн дотны анд нөхдийг салгадаг” гэсэн байдаг. Зүрх сэтгэлд нь хайр болоод сайхан сэтгэл байдаг хүмүүс бусдын буруу, алдаа дутагдлыг далдлахыг хичээдэг. Мөн бусад хүмүүс сайн сайхан, чинээлэг байгаад хэзээ ч агаархаж, хорсдоггүй бөгөөд харин ч хамтдаа баярлаж, аз жаргалтай байж чаддаг юм.

2) Бусдыг шүүн дүгнэж, буруутгаад байдаг бодлоо хаях ёстой.

Та нэгэн итгэгч хүн Христэд итгэгч хүмүүсийн явж болохгүй тийм газар орохыг харлаа гэж бодъё. Энэ үед сэтгэлд хорон муу бодол байвал “Тэр яагаад ийм газар орж байгаан бол?” гэх мэт ямар нэгэн сөрөг муу бодол танд орж ирж болох юм. Хэрэв сайны сэтгэлтэй бол “Яагаад ийм газар явж байгаа юм бол? Ямар нэг учир байгаа биз!” гэж сайн тал руу нь өөрийн бодлоо чиглүүлдэг юм.

Зүрх сэтгэлд хорон муу байхгүй, сүнслэг хайр байгаа хүн нь сөрөг муу бодол санаа огт орж ирдэггүй юм. Хэдийгээр бусдын тухай таагүй мэдээлэл сонссон ч та өөрийн биеэр шалгаж, баталгаатай болоогүй л бол ямар ч хүнийг буруутгаж, шүүн дүгнэдэггүй байна.

Иаков 4:12т “Хууль Тогтоогч ба Шүүгч нь зөвхөн ганц байдаг бөгөөд Тэр нь аварч, устгаж ч чадна. Харин хөршөө шүүгч та хэн юм бэ?” гэсэн байдаг. Зөвхөн Бурхан л үнэн зөвийг шүүх Шүүгч нь юм. Хэрэв бид бусдыг шүүж байвал энэ нь хорон муу, ёс бус явдал мөн.

Сүнслэг хайрын сэтгэлтэй хүн бол хэдийгээр тэр хүний буруу байлаа ч яаран “Тэр хүний зөв буруу, ийм тийм” гэж шийдвэр гаргадаггүй. Энэ нь түүний гэм бурууг нуун далдалж байгаа хэрэг биш харин түүнийг уучлан хэлтрүүлж, гэмшиж, алдаа дутагдлаа ойлгоход нь тус болохын тулд юм. Сул тал ихтэй хүн байсан ч бид хайрлах л хэрэгтэй бол ийм биш хүмүүстэй бид яаж харьцах ёстой билээ. Хэрэв та бусдыг хялбархан шүүн дүгнэж, буруутгадаг бол танд тэр хэмжээний сүнслэг хайр байхгүй байна гэдгээ ухаарах хэрэгтэй.

3) Хэрэв танд Бурханы хүсэлтэй нийцэхгүй бүх бодол санаа хаях хэрэгтэй.

Хүмүүс ерөнхийдөө өндөр ёс суртахуунтай, эсвэл хүний мөс чанартай, хүнийг сайн, сайхан сэтгэлтэй

хүн гэдэг. Гэвч иймэрхүү ёс суртахуун, мөс чанар нь сайны төгс хэмжүүр болох боломжгүй юм. Учир нь эдгээр зүйлд Бурханы хүслийн эсрэг зүйлс маш олон байдаг. Зөвхөн Бурханы үг л сайн, сайхан сэтгэлийг төгс илэрхийлж чаддаг. Тиймд Бурханы үгээс зөрчилдөж буй зүйл нь бүгд гэм нүгэл, ёс бус зүйлс юм.

Бид Эзэнийг хүлээн авбал өөрийгөө гэмтэн байсан гэж хүлээн зөвшөөрдөг. Магадгүй тэр урьд нь өөрийгөө сайхан сэтгэлтэй байсан гэж боддог байсан ч хичнээн цайлган амьдардаг байсан ч Бурханы үгээр гэрэлтүүлэхэд худал хуурмаг, ямар их гэм нүгэл, ёс бус зүйлс байсныг олж мэдээд өөрийгөө гэмтэн гэж хүлээн зөвшөөрч гэмшдэг.

Тэгвэл гэм нүгэл болон хорон муу, ялгаа нь юу вэ?

Модоор зүйрлэвэл “Хорон муу, болон атгаг санаа” гэдэг бол газарт байгаа үндэс шиг нүдэнд харагддаггүй, харин “гэм нүгэл” гэдэг нь яг л модноос салаалан гарсан мөчир, навч, үр жимстэй адил юм. Яг л үндэснээс мөчир, навчис, үр жимс гардагтай адил, “гэм нүгэл” бол “атгаг, хорон санааны” үр жимс нь юм.

Атгаг, хорон санаа нь яг л үндэс газар доорх гүнд байдаг шиг хүний зүрх сэтгэлд угаасаа байж байдаг зүйл. Энэхүү атгаг санаа бол ямар нэг үйлдэл хийхэд хүргэх эсвэл бодол санаанд бодитоор оршин тогтнож байгаад “гэм нүгэл” хийхэд хүргэдэг. Лук 6:45д “Сайн хүн зүрхнийхээ үнэт баялагаас сайныг гаргадаг. Хорон муу нэгэн хорон муу баялгаасаа мууг гаргадаг аж. Учир нь зүрх юугаар дүүрснийг ам нь ярьдаг” гэсэн байдаг билээ.

Хорон муу үгтэй нэг хүн хэн нэгнийг үзэн ядаж, доромжиллоо гэж бодъё. Энэ үед үзэн ядах гэдэг атгаг санаа түүний зүрх сэтгэлд байсан болохоор л “хорон муу үг” “доромжлол”-р гэм нүгэл болон гарч байгаа юм. Гэвч хэдий их муухай хорон сэтгэлтэй байсан ч хүн бүр түүнийгээ гэм нүгэл болгон гаргаад байдаггүй. Бурханы үгийн дагуу өөрийгөө хянах чадвартай, сахилга бат сайтай хүмүүсийн дотор байгаа атгаг санаа нь гэм нүгэл болон гарч чаддаггүй. Харин тэдний зүрх сэтгэл дотор нь атгаг, хорон сэтгэл байсаар байгаа учраас үнэхээр сайхан сэтгэлтэй ариун болсон хүмүүс гэж хараахан хэлж болохгүй. Бүх гэм нүглийн шинж чанарыг зүрх сэтгэлээсээ үндсээр нь авч хаясан цагт л сүнслэг хайрыг олж авч, ариуссан хэмээн хүлээн зөвшөөрөгдөх болно.

Бурхан бол хайр. Бурханы сургаалуудыг товчоор хэлбэл “Хайр” гэж ойлгож болно. Иймд бидний санах ёстой зүйл бол атгаг хорон сэтгэл, гэм нүгэл гэдэг нь зөвхөн бусдыг үзэн ядах, дургүйцэх явдал биш,

эцэстээ хайр байхгүй байна гэдэг нь мөн хорон муу сэтгэл ба гэм нүгэл болохыг ойлгож ухамсарлах хэрэгтэй юм. Тиймээс бид атгаг, хорон муугийн аливаа ямар ч хэлбэрийг бүрэн хаяж, бусдыг илүү их хайрлах ёстой юм.

2. Сүнслэг хайрыг олж авахын тулд

Дээр дурдсан бүх зүйлээс худал, хуурмаг, ёс бус зүйлсийг сонсохгүй, үзэж харах ч ёсгүй юм. Хэрэв сонсож, үзэж харсан бол түүнийгээ санахгүй, дахин дахин бодохгүй байхыг хичээх хэрэгтэй. Гэвч харамсалтай нь хамгийн хэцүү нь биднийг хорон муугаас салахыг хичээх тусам нөгөө бодол санаанууд дахин дахин бодогдож, тархинд байсаар л байдаг. Тийм л учраас бид гал халуун залбирч, Ариун Сүнсний тусламжийг авах хэрэгтэй. Мэдээж тэдгээр зүйлсийг зориудаар, санаатайгаар дахин дахин бодох шаардлагагүй шүү дээ. Тэдгээр бодол санаанууд тархинд зурсхийн орж ирэх үед бид шууд хаях хэрэгтэй байдаг. Хорон муу үйлсийг хийх ч хэрэггүй гэдэг нь та бидэнд одоо тодорхой болж байгаа байх.

Хүн эцэг эхээсээ угийн гэмт чанарыг өвлөн авахаас гадна амьдралаас маш олон гэмт чанарыг олж авдаг. Энэ бүх гэм нүгэл, худал хуурмаг дээр үндэслэгдсэн “Би” гэдэг том хүрээг хувь хүн өөртөө бий болгодог. Тиймээс бид бүхэн энэ угийн гэмт чанар, худал хуурмагийг авч хаяхын тулд тэвчээр хатуужил, хичээл зүтгэл гаргах хэрэгтэй. Бид зөвт байдлаас илүүтэйгээр худал хуурмагтай ойр дотно болчихсон байдаг учраас авч хаяхаасаа илүү хүлээн зөвшөөрөх нь их байдаг. Хэрэв та хэн нэгэнд маш их хайртай болчихвол түүний дургүй зүйлийг та хийх дургүй болж, дургүй зүйлийг нь ч та бас хийх дургүй болдог. Яг үүнтэй адил бид Бурханыг дээд зэргээр хайрлавал түүний үг сургаалыг сахиж, хорон муугийн бүх хэлбэрийг хаяж чадна.

Түүний дараа сүнслэг хайрыг олж авахын тулд юуны түрүүнд “амийн талх” болсон Бурханы үгээр зэвсэглэж, гал мэт залбирал хэрэгтэй билээ. Бид өдөр шөнөгүй Бурханы үгийг санан бясалгавал хорон муу бодол санаагаа хаяж сайн бодлоор өөрийгөө чиглүүлэн мөн гал халуун залбирсанаар өөрөө ч мэддэггүй байсан хорон муу бодол санаа, үг, үйлдлээ мэдэж авч, түүнийгээ хаяж чаддаг болох юм.

Хайрт итгэлийн ахан дүүс минь, сүнслэг хайр бол хэзээ ч муутай тооцоо хийдэггүй юм. Гал халуун залбирал болон Бурханы үгээр зэвсэглэн маш хурдан хорон муугийн бүх хэлбэрээ хаяж, зөвт байдал дотор сайныг үйлдэж, сайхан сэтгэл, эерэг зөв бодол санаатай сүнслэг хүн болохыг Их Эзэнийхээ нэрээр хүсэн ерөөе.

Монгол Манмин Төв Сүм

Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30

Залбирлын цаг

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



Хаяг: Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С
Утас: чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

www.manmin.org
www.manmintv.org

Ер бусын эртний гайхамшигуудыг чухам хэн хэзээ бүтээсэн бэ?

“Ер бусын гайхамшиг” гэсэн нэр томъёо нь “хүн төрөлхтөний төсөөлж ч чадамгүй, сонин тайлагдашгүй зүйл” гэж илэрхийлж болох юм. Эртний олдворууд ч энэ л тайлагдашгүй нууцад багтдаг. Хэдэн мянган жилийн өмнөх хүмүүсүүдийн ойлгоход ч хэцүү мэдлэг, болон арга техник нь түүнд агуулагдаж байгаа бөгөөд харин ч эсрэгээр орчин үеийн технологос ч давуу тал байгаа учраас эртний хүмүүс хийсэн гэхэд итгэхийн аргагүй юм. Мөн хүний төсөөлөхийн ч аргагүй аргаар бүтээгдсэн зүйлс олон байдгийг харж болохын адил түүний нэг нь дэлхийн 7 гайхамшигт багтах Пирамид, Сфинкс, Назкагийн жим, болон үр тариан тойрог гэх мэт олон зүйлсийг ч хэн, хэзээ, яаж хийснийг хариулж чадахгүй байсаар л байна. Эдгээр асуултнуудад бид маш товчхон хариулт өгье. Харин дэлгэрэнгүй тайлбар нь И Жей руг пасторын “Эхлэл тайлбар” сургаалд дурьдсан байдаг билээ.



Еден Цэцэрлэг дэх Адам болон түүний үр удмын мөр

Библид анхны хүн Адам нь амьд оршигчынхоо хувьд элбэг дэлбэг зах хязгааргүй мэт асар уудам Еден цэцэрлэгт бидний төсөөлшгүй асар их олон жилийн хугацаанд амьдарч, бүх бүтээлийн дээд оргил болохынхоо хувьд агуу их эрх мэдлийг эдэлж байлаа. Бурхан түүнд болон түүний үр удамд Еден цэцэрлэгийг бүтээж өгсөн бөгөөд Адамыг гэм хийснийх нь дараа ч амьдран

суурьших газар, өөрөөр хэлбэл хүн төрөлхтөнийг дасгалжуулах энэ дэлхийг ч Бурхан Өөрөө бүтээсэн юм. Тэгээд Адам Еден цэцэрлэгт амьдарч байхдаа өсөн үржин үй олон үр удамтай болсон ба Бурхан түүнд энэ бүхнийг бүгдийг бүр дэлхийг ч удирдан захирах эрх мэдлийг өгсөн байв.

Амьд оршигч Адам нь Бурханаас өгсөн мэргэн ухаан ба Еден цэцэрлэгийн дээд зэргийн технологиор нисдэг хөлөг мэт зүйл хийн, Еден цэцэрлэг болон дэлхий рүү ирж, очин ихэвчлэн Египетийн Нил мөрний хавиар ирдэг байсан бөгөөд энэ газарт ямар нэгэн билэгдлийн чанартай зүйлс үлдээхийг хүсжээ. Тэрээр Ариун Эцэг, Ариун Хүү,

Ариун Сүнс болох Гурвын нэг Бурханыг алдаршуулах хэлбэр дүрстэй, гайхамшигтай хэмжээтэй, цорын ганц барилга барихаар төлөвлөсөн нь одоогийн “Пирамид” юм. Мэдээж энэ газар дээрх бүх пирамидуудыг Адам бариагүй ч тэрээр пирамидын барилгын эхлэлийг тавьсан гэсэн үг юм.


Адамыг гэм үйлдэж, Еден цэцэрлэгээс хөөгдсөнийх нь дараа Бурхан зарим хүүхдүүдэд нь тусгай орон зайгаар дэлхий рүү явж эцэг эхтэйгээ уулзахыг зөвшөөрсөн байна. Тэд энэ дэлхийд ирээд явахдаа ул мөрөө үлдээж байсан бөгөөд тэр нь одоог хүртэл тайлагдахгүй байгаа нууцлаг зүйлс, гайхамшигууд болон бидний дунд үлдсэн юм.

Египет дэх Гизагийн гурван Пирамид

Алдарт Пирамид нь 147 м өндөр, барагцаалбал нэг бүр нь 2,5 тонн жинтэй 2,3 сая шохойн чулуун блок орсон бөгөөд эдгээр чулуунууд нь яг л дүфү шиг тэгш өнцөгт хэлбэрээр цэвэрхэн зүсэгдсэн бөгөөд өнцөг ба булан, тэгшхэн ирмэгээр нь нарийн тааруулж өрсөн байдаг.

Алдарт Пирамид нь 6 сая тонноос илүү хүнд гэж тооцогддог ба олон мянган жилийн өмнө баригдсан ч суурьнаас дээшхи хүндийн жинг тэнцүүлэхийн тулд ердөө л 5 миллиметр зөрүүтэй байхаар анхнаасаа төлөвлөн өрсөн байдаг. Пирамидын суурь нь тэг дөрвөлжин, 4 тулгуурын шугам нь маш нарийвчлалтайгаар хойд, өмнө, зүүн, баруун зүгийг тодорхой заасан байдаг. Үүнээс гадна энэ гурван пирамид нь Гурван марал гэж нэрлэгддэг одны ордтой адил хэмжээст багтдагаараа онцлогтой.

Энэ мэт ингэж тайлбарласны учир нь энэхүү Пирамид нь математик, одон орон судлал болон өндөр хүчин чадал бүхий техник хэрэгсэлийг ашиглан, асар өндөр мэдлэг чадвараар баригдсан барилга болох нь харагдаж байна.



Пирамидын өмнөх Сфинкс

Энэ 3н пирамидын голд дунд талын пирамидын өмнө Сфинкс нь байдаг. Яг л энэ 3н пирамидыг хамгаалж байгаа мэт харагдана. Зүүн зүг рүү харсан хүн толгойтой, арслангийн бие байдаг бөгөөд ойролцоогоор 74 м урт, 20 м өндөр. Уг Сфинксийг асар том чулууг сийлж хийсэнийг харвал ямар агуу, аварга том чулуу байсныг нь төсөөлж болох юм. Хамгийн гайхалтай нь үнэндээ олон мянган жил өнгөрсөн ч чанар нь сайн, бат бөх хэлбэр төрхөө хэвээрээ хадгалсан байгаад оршино.

Назкагийн жим

Перугийн өмнөд хэсэгт орших элсэн цөлд “Назкагийн жим” гэдэг гайхамшигтай газар байдаг юм. Энэ газар нь 320 кв км газарт ойролцоогоор 200 геометрийн дүрс 30 амьтадын дүрс зурагдсан байдаг. Энэ зураг маш том учраас илүү өндөрт гарч байж л ялган харах боломжтой юм. Жишээлбэл нэг шувууны дүрс гэхэд л 120 м урт бүр 8 км урт геометрийн дүрс ч байдаг. Өөр бас нэг сармагчины дүрс 122 м урт, 91 м өргөн, яг нэг шугаман дээр үргэлжлэн зурагдсан байдаг. Амазоны шигүү ойн хамгийн хол, алсад орших олж очиж ч чадахааргүй хэсэгт “Рисинулей” гэдэг маш ховор төрлийн аалзны зураг ч бас байдаг. Назкагийн цөл нь хүн оршин сууж амьдрахад дэндүү хуурай эзгүй хоосон тул энэ газарт хүн суурьшин амьдарч байсан тэмдэглэл байдаггүй.



Үр тариан тойрог

Бас нэг тайлагдашгүй нууцын нэг бол үр тарианы тойрог дүрснүүд юм. Энэ нь яг тариан талбайн голд нь өвс, тариа будаа ургасан байгаа тэгш хавтгай газарт янз бүрийн геометрийн дүрс, эсвэл маш том тойрог хэлбэрээр зурагдсан байдаг. Энэ нь орчин нөхцөл, цаг агаар, зураг зүйн байрлалаас үл хамаарч ихэвчлэн маш богино хугацаанд ганцхан шөнийн дотор зурагдаж бий болдог байна. Энэ тойрог нь хүний гараар хийгдэж байгаа нь илэрхий бөгөөд хэзээ ч дахин давтагдашгүй өөр өөр байдаг. Үүнийг хийсэн хүмүүсийн нь ойролцоох тарианы үндэс нь тахийгаад хугарч, хатсан байдаг ч дараа нь бүр цоо шинээр, их гоё, үзэсгэлэнтэйгээр ургасан байдаг байна.

“Ээж маань GCN TV-р зуны цуглааныг үзэж байхдаа хараа нь сайжирсан”

Кан Хе жон туслагч
(2-14 хэсгийн итгэгч, Өмнөд Солонгос)

2013 оны 8-р сарын 5нд Манмины зуны цуглаанд оролцож байхдаа би утсаар ээжээсээ гэнэтийн дуудлага хүлээн авсан юм. Тэрхэн үед би хөдөө ганцаараа байсан ээж маань яасан юм бол “яагаад ээж маань өдийд над руу залгадаг билээ?” гэсэн бодол тархинд гялсхийн бодогдож, санаа зовон утсаа авахад түүний дуу хоолой нь баяртай байгааг сонсоод би тайвширч билээ. “Охин минь! Чиний хэлсэнээр би GCN TV-р зуны цуглааныг үзэж байна. Гэв гэнэт ээж нь бүх юмыг тод сайн хардаг болоод гайхаж баярласандаа чам руу ярьж байна” гэж хэлсэн.

Миний ээж 20 жилийн турш чихрийн шижин өвчний хүндрэлээс болоод нүдний хараа маш муу байсан. Тэр 3 жилийн өмнө нүдний болорт сэв суусаны улмаас хагалгаанд хүртэл орж байсан. Хагалгааны дараа ч мөн л түүний нүд юм сайн харахгүй, 6 сард нэг удаа тариа тариулдаг байлаа. Харин И Жей руг пасторын өвчин эдгээх залбирлаар эдгэрсэн олон хүний гэрчлэлийг үзэж байхдаа түүний нүдний хараа сайжирч эдгэрсэн юм. Халлелүя!

И Жей руг пастор нь “Манмины зуны цуглааныг шууд дамжуулж байгааг үзэж байхад ч цаг орон үл хамааран нөлөөлөх болно” гэж айлдаж байсан нь бодитоор биелэж, ээж маань эдгэрч ийм агуу ивээлийг авсанд миний сэтгэл үнэхээр их баясан хөдөлж байлаа. Миний ээж өөр сүмд явдаг ч GCN TV-г үзэх дуртай. Тэр өглөөнөөс орой хүртэл үзэхдээ маш их баяр хөөр аз жаргалыг мэдэрдэг.

Би бүх талархал, алдар магтаалыг цаг хугацааг даван гарч гайхамшигийг бүтээгч Бурхандаа өргөж байна.



“Ариун сайн мэдээ нь сүнс ба бие сэтгэлд ивээл ерөөл өгдөг эрхэм чухал авралын зар юм”

Григорий Колессов пастор (Эстон улс, Үнэний эх булаг сүм)

Анх эстон хэлээр гарсан сонин болон “Амьдрал” ТВ-р гарсан мэдээлэл нь намайг Манмин Төв Сүмтэй холбож өгсөн юм. Энэ нь 2003 онд И Жей руг пасторын Орост хийсэн нэгдсэн их цуглааны талаарх мэдээлэл юм. Тус цуглаанаар Бурханы гайхамшигууд бий болж байсныг олж үзээд их гайхсан юм. Түүнээс хойш 7 жилийн дараа би фейсбүүкээр танилцсан Роняа буюу Сун Ёон раг туслагчаар дамжуулан И Жей руг пасторын номлосон ариун сайн судлаж эхэлсэн.

2010 онд Эстонд болсон нэгдсэн их цуглаанаар дамжуулан хүсэл мөрөөдөл минь улам бат болов

Миний том охин Анастасия маань 6 жилийн турш гэдэсний өвчнөөр шаналж байсан бөгөөд 2010 оны 7-р сарын эхээр И Жей руг пасторын залбирлаар эдгэрсэн бөгөөд Түүний залбирал мянга мянган км, цаг хугацааг даван гарсан агуу их хүчтэй байсан. 2010 онд Финландад болсон Манмин Төв Сүмийн ММБТ (Манмин миссионер бэлтгэх төв)-ийн зохион байгуулсан “Загалмайн утга учир кэмп”-н сургалтанд оролцож, их эрч хүч, ивээлийг авсан юм.

И Жей руг пасторын айлддаг сайн мэдээний гол цөм нь Есүс Христийг дуурайсан Христэч итгэлийн амьдралын талаар сургаал номлосон. Мөн төдийгүй эрх мэдэлт хүч болон дагалдах тэмдгүүдээр Бурханы үг үнэн болохыг батлан харуулдаг Түүний үйлс нь үнэхээр сэтгэл хөдлөм байлаа.

Ямар ч эргэлзээгүйгээр 2010 оны 9-р сард би сүмээ Манмины салбар сүмээр бүртгүүлсэн. Тэгээд маш идэвхитэйгээр дэмжиж, И Жей руг пасторын 2010 оны 10-р сард болсон Эстоны нэгдсэн их цуглааныг идэвхитэйгээр сурталчилж байлаа. Энэ ариун сургаал нь надад гайхалтай өөрчлөлтийг авчирч, миссионерээр ажиллах алсын хараа өгч, өөрийгөө өөрчилж, сүнсээр өсөж, ариусах чин хүслийг төрүүлсэн явдал юм.

Би Манмин Төв Сүмд ирсэн нь

Сүнсээр өсөхийн төлөө залбирч байхдаа 2013 оны 8-р сард том охинтойгоо Манмин Төв сүмд очихоор

шийдсэн юм. И Жей руг пастортай хувьчлан уулзаж, Төв Сүмийн Зуны Цуглаанд гадаадын 22 орны хүмүүстэй хамт оролцох нь миний хувьд маш хүндтэй нэр төрийн хэрэг байлаа.

Зуны цуглааны эхний өдөр гайхамшигтай агуу хүч чадлыг би нүдээрээ харсан. Тэргүүн Пасторыг номлож эхлэх үеэр том том дусалтай бороо орж байсан билээ. Бороог зогсоох залбирал хийхэд өтгөн хар үүлс замхран алга болж, тэнгэрт цоорхой гарч бидний байгаа газраас тэнгэр цэлмэг болон харагдаж байлаа.

Тэргүүн Пастор номлосонхоо дараа өвчин эдгээх залбирал хийхэд гадаад дотоодын маш олон хүн түүний залбирлаар эдгэрч, баяр хөөрөөр дүүрэн байсан. Энэ үйл явдал ч бас миний сэтгэлийг маш ихээр хөдөлгөж байсан бөгөөд Галын наадам, магтан дууны үеэр Ариун Сүнсний оршихуй дүүрч байсан юм.

2013 оны Манмины зуны цуглаанаар би ариун сайн мэдээг тараахаар шийдсэн нь

И Жей руг пасторын сургаал бол хий хоосон онол бус харин ч маш нарийн тодорхой яаж зүрх сэтгэлдээ байгаа хорон муу зан чанар, гэмийг хаян Эзэнийг дуурайж болох, хэрхэн илүү сайн тэнгэрийн оронд орох (Матай11:12) зэргийг маш нарийн нэг бүрчлэн зааж сургадаг.

Би ариун зар, сургаалыг интернетээр Скайп ашиглан тарааж байгаа билээ.

Зуны цуглааны дараа би Манмин залбирлын хүрээлэнгийн удирдагч И Буг ним удирдагчын удирдан явуулах Даниел залбирлын дамжуулан залбирал хичнээн чухал болохыг ухаарсан юм. Тиймд ариун сайн мэдээний төлөө төдийгүй Бурханы хаанчлал болон Түүний зөвт байдлын төлөө орой болгон өргөгдөх Даниел залбирлын цаг Эстонд ч мөн адил хийхийг хүсэж байна.

Энэ мэт ариун сайн мэдээг дамжуулдаг эрхэм үүргийг өгсөн Бурхандаа бүхий л алдар, магтаал, талархалыг өргөж байна.



Улаанбаатар Манмин Сүм

Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57 тоот Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган

Чуулганы утас: 976-11-351437

Чуулганы хариуцсан төлөөлөгч:
Г. Анхбаяр СМТ 976-91173712
976-91615337

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

235-3 Гуро-Здонг, Гуро-гу, Сеул,
152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
http://www.manmin.org/english
www.manminnews.com
e-mail: manminministry@manmin.org
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин